



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 10 өдөр

А/437

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, Төсвийн тухай хуулийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж буй "Далайн-элбэрэлт" өрхийн эрүүл мэндийн төвөөс "Хөх толгой" хэсэгт ажиллах эмчийн урамшуулалд 1,500,000 төгрөг, "Энэрэл", "Гурван-Гал", "Энх-үйлс", "Дэлгэрмөрөн" өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны дэмжлэгт тус бүр 200,000 төгрөгийг үзүүлсүгэй.

2. Дээрх 2,300,000 (Хоёр сая гурван зуун мянган) төгрөгийг "Засаг дарга" данснаас зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД